



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ 2018



2019 ОН

ӨМНӨХ ҮГ

Улс орны бүхий л салбарын бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, богино, дунд болон урт хугацааны төлөвлөлт хийх үндсэн эх үүсвэрийн нэг нь хүн амын тоо, бүтцийн талаарх цогц мэдээлэл юм.

Хүн ам зүй нь хүн амын тоо, бүтэц, өсөлт, өөрчлөлт, түүний үр дүнг нийгэм эдийн засгийн өөрчлөлтүүдтэй холбон авч үзэж, учир холбогдлыг тайлбарладаг шинжлэх ухаан юм.

Энэхүү судалгааг хүн ам зүйн дүн шинжилгээ хийх, тэдгээрт чиглэгдсэн Засгийн газрын бодлого, хөтөлбөр боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийх үнэлэлт, дүгнэлт өгөхөд орон нутгийн бодлого боловсруулагч нар өдөр тутмын ажлын хэрэгцээндээ ашиглахаас гадна хэрэглэгчид хүн амын талаархи мэдээллийг олж авахад ашиглах юм.

Бодлого боловсруулагч, төлөвлөгч нарын өдөр тутмын үйл ажиллагаа нь ажилгүйдэл, ядуурал, эдийн засгийн түвшин, боловсрол, эрүүл мэнд, үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах, хүн бүрийг амьжиргааны түвшнээс дээгүүр амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдэж байдаг. Энэ утгаараа хүн ам зүйн статистикийн үндсэн үзүүлэлтүүд (хүн амын тоо, нас, хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, гэрлэлт, гэр бүл салалт, шилжилт хөдөлгөөн)-ийн талаархи судалгаа нь та бүхний ажилд хувь, нэмрээ оруулна гэдэгт итгэж байна.

Статистикийн хэлтэс нь аймгийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн статистик мэдээллийг сар, улирал, жилээр гаргаж гүйцэтгэх засаглалын байгууллагын эрэлт, хэрэгцээг хангаж байгаагийн зэрэгцээ статистикийн мэдээллээ ашиглан сэдэвчилсэн судалгаануудыг хийж ирсний нэг нь хүн амын нийгмийн үндсэн үзүүлэлтийн танилцуулга юм.

Хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй болгох зорилгоор хүн ам зүйн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолтыг хийсэн болно.

ХҮН АМ ЗҮЙН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ

СУУРИН ХҮН АМ - гэдэгт тухайн засаг захиргааны нэгжид 183 хоног буюу сараас дээш хугацаагаар оршин суугаа хүн амыг харуулдаг.

ХҮН АМЫН ТООНЫ ӨСӨЛТ, БУУРАЛТ - тодорхой хугацааны туршид хүн амын тооны эерэг өөрчлөлтийг хүн амын тооны өсөлт, сөрөг өөрчлөлтийг хүн амын тооны бууралт гэнэ.

ӨРХ - гэдэг нь нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн болон гэр бүлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.

ХҮН АМЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ТОО - Тайлант оны эхний болон эцсийн хүн амын дунджаар илэрхийлэгдэнэ.

ХҮН АМЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТИЙН ХУВЬ - Өгөгдсөн хугацаан дахь хүн амын тооны бодит өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ. Тайлант оны хүн амын тооноос суурь болгон авсан хүн амын тоог хасч, дээрх 2 оны хоорондох хугацаа болон суурь оны хүн амын тоогоор үржсэн үржвэрт харьцуулж, 100-аар үржүүлнэ.

ХҮН АМЫН ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ, БУУРАЛТ - Тухайн жилийн хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр илэрхийлэгдэнэ.

ХҮН АМЫН ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ(БУУРАЛТ)-ЫН КОЭФФИЦИЕНТ - Хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр тухайн жилийн хүн ам өссөн, буурсныг харуулах коэффициент бөгөөд түүнийг суурин хүн амд эзлэх хувиар илэрхийлнэ.

ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН БҮТЭЦ - Насны бүлэг тус бүр дэх эрэгтэй, эмэгтэй хүн амын тоог хувийн жингээр илэрхийлнэ. Хүн амын нас хүйсийн бүтэц нь төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний өнгөрсөн үеийн чиг хандлагын өсөн нэмэгдсэн үр дүн юм.

ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН СУВАРГА - Хүн амыг нас, хүйсээр хуваарилан харуулдаг босоо байрлалтай диаграмм юм. Онолын хувьд босоо тэнхлэгт нийт хүн амд тухайн насны хүн амын эзлэх хувийн жингээр харуулах ба бага насныхныг суваргын доод хэсэгт, хэвтээ тэнхлэгийн зүүн талд эрэгтэйчүүд, баруун талд эмэгтэйчүүд тус тус дүрслэн харуулдаг. Хүн амын нас, хүйсийн пирамид нь цаг хугацааны тодорхой үеийн хүн амын нөхөн үржихүйн тасралтгүй процессийн явцыг харуулна. Хэрэв хүн амын нөхөн үржихүйн процессийн тухайлбал төрөлт, нас баралтын түвшинд ямар нэг нөлөө гараагүй тохиолдолд насны пирамид нь тэнцүүхэн дүрслэгдэх ба урт хугацааны туршид төрөлтийн өндөр түвшин хадгалагдаж, нас баралтын түвшин ч харьцангуй өндөр байсан тохиолдолд пирамидын суур нь өргөн, орой руугаа нарийссан хэлбэртэй, харин

төрөлт, нас баралтын түвшин бага байсан тохиолдолд пирамидын суурь нь нарийхан, орой руугаа өргөссөн хэлбэртэй байна.

ХОТЫН ХҮН АМ ӨРХ - Нийслэл, аймгийн төв, тосгонд суугаа хүн ам, өрхийг хамруулна.

ХӨДӨӨГИЙН ХҮН АМ ӨРХ - Сумын төв, (аймгийн төвийн сумыг оруулахгүй), хөдөөд оршин суугаа бүх хүн ам, өрхийг хамруулна.

ХҮЙСИЙН ХАРЬЦАА - Эрэгтэй хүн амын тоог эмэгтэй хүн амын тоонд харьцуулсан харьцаа бөгөөд энэ нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлнэ.

ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ - Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээгдэгчийн тоо (15-аас доош, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо) буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн амын насны бүлгийн бүтцээр илэрхийлнэ.

ХҮН АМЫН НЯГТРАЛ - Нэгж газар нутагт ногдох хүн амын тоог илэрхийлнэ.

ХҮН АМЫН СУУРЬШИЛ - Хүн амын нутагшилт, тархалтын хэв маягийг илэрхийлнэ.
Жнь: Хот, хөдөөд г.м

ТӨРӨХ ҮЕИЙН ХҮЙСИЙН ХАРЬЦАА - Тухайн жилд амьд төрсөн 100 эмэгтэй хүүхэд тутамд ногдох амьд төрсөн эрэгтэй хүүхдийн тоог хэлнэ.

ТӨРӨЛТИЙН ЕРӨНХИЙ КОЭФФИЦИЭНТ - Тухайн жилийн 1000 хүн ам тутамд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог гэнэ.

ТӨРӨЛТИЙН ТУСГАЙ КОЭФФИЦИЭНТ - нь төрөх насны /15-49 насны/ 1000 эмэгтэйд ногдох төрөлт юм.

НАС БАРАЛТЫН ЕРӨНХИЙ КОЭФФИЦИЭНТ - 1000 хүн ам тутамд ногдох нас баралтын тоог гэнэ.

АГУУЛГА

А. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүн амын тоо, түүний өсөлт
Хүн амын нас, хүйсний бүтэц
Хүн амын суурьшилт, нягтшил
Хүн амын ердийн хөдөлгөөн
Хүн амын шилжилт хөдөлгөөн

Б. ХҮН АМЫН НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өрхийн үзүүлэлт
Нийгмийн зарим үзүүлэлт

В.ХАВСРАЛТ

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт1.1 Хүн амын үндсэн үзүүлэлтүүд, 2018 он
Хүснэгт1.2 Хүн амын тоо, сумдаар, оны эцэст
Хүснэгт1.3 Сумдын хүн амын тооны өсөлт, хувиар 1979-1989, 1989-2000, 2000-2010, 2010-2018 он
Хүснэгт2.1 Хүн амын тоо, хүйсээр, оны эцэст
Хүснэгт2.2 Хүн амын тоо, хүйсээр, сумаар, 2010,2017,2018 он
Хүснэгт2.3 Хүн амын тоо, нас, хүйсээр, 2010,2016-2018 он
Хүснэгт2.4 Хүн ам зүйн ачаалал, 1979,1989,2000,2010,2014-2018 он
Хүснэгт2.5 Хүн амын тоо, хүйсээр, сумаар, 2010,2016,2017 он
Хүснэгт3.1 Хүн амын тоо, суурьшлаар, сумдаар, 2016-2018 он
Хүснэгт3.2 Хүн амын нягтрал, сумаар, 1989,2000,2010,2018 он
Хүснэгт3.3 Хүн амын нягтрал, сумаар, 1989, 2000, 2010, 2017 он
Хүснэгт3.4 Сумдын хүн амын тооны бүлэглэлт, 2017 он
Хүснэгт4.1 Хүн амын төрөлт, нас баралт, хүйс байршлаар
Хүснэгт4.2 Төрүүлсэн хүүхэд, эхийн насаар, 2018 он
Хүснэгт4.3 Төрөлтийн тусгай коэффициент, насны бүлгээр, оны эцэст
Хүснэгт4.4 Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн насны бүтэц, хувиар
Хүснэгт4.5 Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн боловсролын бүтэц, хувиар
Хүснэгт4.6 Гэрлэлт, цуцлалтын ерөнхий, тусгай коэффициент
Хүснэгт4.7 Үрчлэлт, хүүхдийн насны бүлгээр, 2018 он
Хүснэгт5.1 2018 оны шилжилт хөдөлгөөний урсгал
Хүснэгт5.2 Хүн амын шилжилт хөдөлгөөн
Хүснэгт4.10 Нас барсан хүний тоо, насны бүлгээр
Хүснэгт4.11 Насны бүлэг дэх нас баралтын коэффициент, хүйсээр
Хүснэгт4.12 Үрчлэлт, хүүхдийн насны бүлгээр

Хүснэгт4.13 Бүртгүүлсэн гэр бүлийн тоо
Хүснэгт4.14 Гэрлэлтээ цуцлуулсан гэр бүлийн тоо
Хүснэгт5.1 2017 оны шилжилт хөдөлгөөний урсгал
Хүснэгт6.1 Өрхийн тоо, сумаар, байршлаар
Хүснэгт6.2 Хүн ам нийгмийн зарим үзүүлэлт, сумаар
Хүснэгт6.3 Хүн ам нийгмийн зарим үзүүлэлт, сумаар
Хүснэгт6.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, төрлөөр 2018 он
Хүснэгт7.1 Хүн амын тоо, насны ангиллаар, хүйсээр
Хүснэгт7.2 Төрөлт, нас баралт, гэрлэлт, цуцлалт 2017,2018 он
Хүснэгт7.3 1000 хүн амд ногдох төрөлт, нас баралт, сумаар, оны эцэст
Хүснэгт7.4 Хүн амын шилжилт хөдөлгөөн, шилжилт хийгдсэн аймаг, нийслэлээр
Зураг1.Хүн амын тоо, жил бүрийн эцэст, 2000,2010-2018 онд
Зураг1.2 Хүн амын тоо, өсөлтийн хувь, оны эцэст
Зураг1.3 Даланжаргалан, Мандах, Сайншанд сумдын хүн амын тоо, сүүлийн 5 жилд
Зураг1.4 2010-2018 оны хүн амын жилийн дундаж өсөлт, сумдаар
Зураг1.5 Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь
Зураг2.1 Хүн амын хүйсийн харьцаа, 2018 онд
Зураг2.2 Хүн амын нас хүйсийн бүтэц
Зураг2.3 Хүн амын тооны бүтэц, насны ангиллаар
Зураг3.1 Нийт хүн амын тоо, суурьшил, бүтцээр, 2010,2018 он
Зураг3.2 Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээ, мян,км²
Зураг3.3 Сумдын хүн амын аймгийн дүнд эзлэх хувь, 2010,2018 он
Зураг4.1 Хүүхэд төрүүлсн эхчүүдийн гэр бүлийн байдал, хувиар
Зураг4.2 Гэрлэлт, цуцлалтын тоо, 2014-2018 он
Зураг5.1 Шилжин ирсэн, явсан хүн амын насны бүтэц, 2018 он
Зураг5.2 Шилжилт хөдөлгөөнд оролцогчдийн бүтэц, 2002-2018 он
Зураг6.1 Өрхийн ам бүлийн тоо, дүнд эзлэх хувиар, оны эцэст
Зураг6.2 Өрх толгойлсон эх, өрхийн гишүүдийн тоогоор, эзлэх хувиар, 2017,2018 он
Зураг6.3 Хагас, бүтэн өнчин хүүхдийн тоо, 2009-2018 он
Зураг6.4 Хөгжийн бэрхшээлтэй иргэдийн тоо, 0-14 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 2009-2018 онд

А.ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


НЭГ. ХҮН АМЫН ТОО, ТҮҮНИЙ ӨСӨЛТ

ХҮСНЭГТ1.1 ХҮН АМЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2018 онд

I	ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	БҮГД	Эрэгтэй	Эмэгтэй
	Жилийн эхний хүн ам	69182	34116	34076
	Жилийн эцсийн хүн ам	69560	34916	34644
	Насны бүлгээр			
	0-14 нас	21938	11304	10634
	15-64	45204	22690	22514
	65+	2418	922	1496
	Төрөлт	1596	829	767
	Нас баралт	407	248	159
	Нийт шилжин ирсэн хүн ам	1732	867	865
	Нийт шилжин явсан хүн ам	1688	854	834
	Нийт өрхийн тоо	21286	-	-
	Газар нутаг	109400		
	Жилийн дундаж хүн ам	69371	34516	34360
	Нийт хүн амд эзлэх хувь	99.3	49.8	49.5
	Хүйсийн харьцаа	100.8	-	-
	Төрөлтийн ерөнхий коэффициент	23.0	-	-
	Нас баралтын ерөнхий коэффициент	5.9	-	-
	Ердийн өсөлт (1000 хүнд ногдох)	17.1	-	-
	Механик өсөлт (1000 хүнд ногдох)	0.6	-	-
	Хүн ам зүйн ачаалал			
	Нийт	53.9	-	-
	Хүүхдийн	48.5	-	-
	Өндөр настны	5.3	-	-
	Нэг өрхөд ногдох дундаж ам бүлийн тоо	3.3	-	-


2018 оны эцэст 69560 байнгын оршин суугчтай болж 2017 оны жилийн эцсийн суурин хүн амын мэдээнээс 1368 хүнээр өсчээ. 2000 оны тооллогоос хойш 18985 хүнээр, 2010 оны тооллогоос хойш 9788 хүнээр тус тус нэмэгдсэн байна.

ЗУРАГ1.1 Хүн амын тоо, жил бүрийн эцэст, 2000,2010-2018 онд



Аймгийн хүн амын тоо сүүлийн 9 жилийн хугацаанд 2011, 2012, 2014, 2015, 2017, 2018 онуудад 0.6-2.4 хувиар буурч, бусад жилүүдэд 1.8-5.5 хувиар өсчээ.

ЗУРАГ1.2 ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТИЙН ХУВЬ, оны эцэст



2018 онд хүн амын тоо 2017 оноос 2.1 хувиар, 2000 оны тооллогоос хойш 37.5 хувиар, 2010 оны тооллогоос хойш 16.5 хувиар тус тус өсчээ.

ХҮСНЭГТ1.2 ХҮН АМЫН ТОО, сумдаар, оны эцэст

	2014	2015	2016	2017	2018	2018 2014	2018 2017
Бүгд	63492	63125	66606	68192	69560	109.6	102.0
Айраг	3607	3612	3738	3811	3766	104.4	98.8
Алтанширээ	1286	1262	1294	1327	1360	105.8	102.5
Даланжаргалан	2641	2680	2742	2749	2895	109.6	105.3
Дэлгэрэх	1868	1851	1889	1873	1840	98.5	98.2
Иххэт	2078	2039	2077	2108	2112	101.6	100.2
Мандах	1563	1566	1568	1587	1596	102.1	100.6
Өргөн	1904	1889	1933	2004	2076	109.0	103.6
Сайхандулаан	1276	1292	1367	1380	1378	108.0	99.9
Улаанбадрах	1451	1431	1474	1470	1482	102.1	100.8
Хатанбулаг	2933	2752	2941	2919	2872	97.9	98.4
Хөвсгөл	1567	1518	1568	1573	1540	98.3	97.9
Эрдэнэ	2346	2340	2437	2378	2439	104.0	102.6
Сайншанд	22666	23191	24059	24772	25274	111.5	102.0
Замын-Үүд	16306	15702	17519	18241	18930	116.1	103.8

*Тооллого явагдсан онууд

2018 онд хүн амынхаа тоогоор 25.3 мянган хүн амтай аймгийн төв Сайншанд, 18.9 мянган хүн амтай Замын-Үүд сумд тэргүүлж, 3.8 мянган хүн амтай Айраг, 2.9 мянган хүн амтай Хатанбулаг, Даланжаргалан сумд удаалж байна.

2018 онд өмнөх оноос хүн амын тоо Алтанширээ суманд 2.5 хувь, Даланжаргалан суманд 5.3 хувь, Иххэт суманд 0.2 хувь, Мандах суманд 0.6 хувь, Өргөн

суманд 3.6 хувь, Улаанбадрах суманд 0.8 хувь, Эрдэнэ суманд 2.6 хувь, Сайншанд суманд 2.0 хувь, Замын-Үүд суманд 3.8 хувиар тус тус өсч, бусад сумдад хүн амын тоо буурсан байна.

Дээрх хүснэгтээс харахад сумдын хүн амын тоо сүүлийн 5 жилд Даланжаргалан, Мандах, Сайншанд сумдад өссөн байна.

ЗУРАГ1.3 ДАЛАНЖАРГАЛАН, МАНДАХ, САЙНШАНД СУМДЫН ХҮН АМ, сүүлийн 5 жилд




ХҮСНЭГТ1.3 СУМДЫН ХҮН АМЫН ТООНЫ ӨСӨЛТ, хувиар 1979-1989, 1989-2000, 2000-2010, 2010-2018 он

	Өсөлт (хугацааны эцэс / эх)				Жилийн дундаж өсөлт			
	1979-1989	1989-2000	2000-2010	2010-2018	1979-1989	1989-2000	2000-2010	2010-2018
Бүгд	41.9	-11.4	18.2	16.4	3.23	-1.10	1.37	2.05
Айраг	16.8	5.9	3.8	4.6	1.42	0.52	1.12	-0.32
Алтанширээ	22.4	0.2	-15.8	4.4	1.86	0.02	-2.58	1.49
Даланжаргалан	20.5	3.3	10.7	12.2	1.71	0.30	1.09	1.20
Дэлгэрэх	11.5	13.2	-5.1	2.4	0.99	1.13	-1.05	0.86
Иххэт	69.8	-35.0	-20.6	-1.5	4.93	-3.84	-2.13	0.03
Мандах	75.5	-25.4	-20.8	5.8	5.25	-2.62	-1.89	1.29
Өргөн	6.5	60.3	-7.5	10.7	0.57	4.38	-0.54	2.24
Сайхандулаан	15.4	-6.3	-3.7	11.7	1.31	-0.59	-0.97	1.91
Улаанбадрах	14.1	16.3	-10.9	-3.9	1.21	1.38	-1.72	0.20
Хатанбулаг	17.3	26.3	-7.9	-7.2	1.46	2.15	-1.07	-0.55
Хөвсгөл	13.9	18.1	-9.0	-1.6	1.19	1.53	-1.10	0.00
Эрдэнэ	31.0	30.4	-8.8	-5.5	2.49	2.44	-2.41	1.05
Сайншанд	55.5	-14.8	15.6	19.5	4.10	-1.45	1.22	2.27
Замын-Үүд	41.1	275.0	151.5	37.2	3.18	12.77	9.25	4.01
Сүмбэр	60.2				4.38			


Дорноговь аймгийн хүн амын тоо 1979-1989 онд бүх сумдын хүн ам жигд өссөн, 1989-2000 оны хооронд Иххэт, Мандах, Сайхандулаан, Сайншанд сумдад буурч бусад сумдад өссөн байна. 2000-2010 онд Айраг, Даланжаргалан, Сайншанд, Замын-Үүд сумын хүн амын тоо өсч, бусад сумдад буурчээ. 2010-2018 онд Айраг, Хатанбулаг сумдад хүн амын тоо буурч, бусад сумдад өсөв.

ЗУРАГ1.4. 2010-2018 ОНЫ ХҮН АМЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ, сумдаар




Аймгийн нийт хүн ам 1969-1979 онд 3.25 хувиар өссөн нь хамгийн өндөр өсөлттэй үе байсан бол 1989-2000 онд хүн амын тоо жилд дунджаар -1.10 хувиар буурсан. 2000-2010 онд жилд дунджаар 1.37 хувиар, 2010-2018 онд 2.05 хувиар тус тус өсөв.

ЗУРАГ1.5 ХҮН АМЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТИЙН ХУВЬ



ХОЁР. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

ЗУРАГ2.1 ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2018 онд



Суурин хүн амын 50.2 хувь нь эрэгтэйчүүд, 49.8 хувь нь эмэгтэйчүүд юм. Хүн амын хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо) 100.8 байгаа нь улсын дунджаас 4.1 пунктээр дээгүүр байна.

ХҮСНЭГТ2.1 ХҮН АМЫН ТОО, ХҮЙСЭЭР, оны эцэст

Онууд	Хүн ам (мян.хүн)			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
2000*	50.6	25.5	25.1	101.8
2010*	57.9	28.7	29.2	101.8
2011	60.5	30.2	30.2	99.9
2012	60.9	30.4	30.5	99.9
2013	62.5	31.2	31.3	99.5
2014	63.5	31.7	31.8	99.9
2015	63.1	31.5	31.6	99.7
2016	66.6	33.3	33.3	100.0
2017	68.2	34.1	34.1	100.0
2018	69.5	34.9	34.6	100.9


Хүн амын хүйсийн харьцаа 2018 онд 100.8 болж, 2000 оноос 0.9 пунктээр буурч, 2010 оны оноос 1.0 пунктээр, өмнөх оны мөн үеэс 0.7 пунктээр тус тус өссөн байна. Сайншанд сумдын хүн амын хүйсийн харьцаа аймгийн дунджаас 7.4 пунктээр бага, Сайхандулаан сумын хүн амын хүйсийн харьцаа 19.7 пунктээр их байна.

ХҮСНЭГТ2.2 ХҮН АМЫН ТОО, хүйсээр, сумаар, 2010, 2017, 2018 он

	2010*			2017			2018		
	Бүгд	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Бүгд	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Бүгд	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
Бүгд	57930	28700	101.8	68192	34076	100.1	69560	34644	100.8
Айраг	3877	1858	108.7	3811	1892	101.4	3766	1853	103.2
Алтанширээ	1191	563	111.5	1327	641	107.0	1360	649	109.6
Даланжаргалан	2600	1199	116.8	2749	1342	104.8	2895	1381	109.6
Дэлгэрэх	1704	813	109.6	1873	923	102.9	1840	891	106.5
Иххэт	2107	1009	108.8	2108	1044	101.9	2112	1037	103.7
Мандах	1422	701	102.9	1587	783	102.7	1596	774	106.2
Өргөн	1701	821	107.2	2004	983	103.9	2076	1009	105.7
Сайхандулаан	1162	532	118.4	1380	631	118.7	1378	625	120.5
Улаанбадрах	1456	695	109.5	1470	714	105.9	1482	718	106.4
Хатанбулаг	3018	1468	105.6	2919	1435	103.4	2872	1413	103.3
Хөвсгөл	1540	757	103.4	1573	769	104.6	1540	737	109.0
Эрдэнэ	2220	1108	100.4	2378	1155	105.9	2439	1153	111.5
Сайншанд	20643	10669	93.5	24772	12803	93.5	25274	13069	93.4
Замын Үүд	13289	6507	104.2	18241	8961	103.6	18930	9335	102.8

Хүн амын нас, хүйсийн бүтцийг харуулах гол үзүүлэлтийн нэг бол нас, хүйсийн суварга билээ. 2010 оны нас хүйсийн суваргаас харахад 0-4 нас, 20-29 насны хүн ам дийлэнх хувийг эзэлж байгаа бол 2018 онд 0-9 нас, 25-34 насныхын дийлэнх хувийг эзэлж байна. Энэ нь сүүлийн 10 гаруй жилд төрөлт нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм.

ЗУРАГ2.2 ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН БҮТЭЦ



ХҮСНЭГТ2.3. ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО, НАС, ХҮЙСЭЭР, 2010, 2016, 2017, 2018 он

Насны бүлэг	2010		2016		2017		2018		2018/2010	
	Бүгд	Үүнээс:Эм	Бүгд	Үүнээс:Эм	Бүгд	Үүнээс:Эм	Бүгд	Үүнээс:Эм	Бүгд	Үүнээс:Эм
Бүгд	57930	28700	66606	33304	68192	34076	69560	34644	120.1	120.7
0-4	6688	3302	8120	3907	8049	3844	8204	3909	122.7	118.4
5-9	5116	2586	7123	3485	7481	3686	7837	3806	153.2	147.2
10-14	5315	2704	5180	2600	5442	2696	5897	2919	111.0	108.0
15-19	4698	2349	5155	2614	5222	2661	5143	2584	109.5	110.0
20-24	5780	2789	5302	2587	5176	2541	5154	2573	89.2	92.3
25-29	5974	2730	6514	3163	6535	3173	6165	2980	103.2	109.2
30-34	5343	2575	6095	2918	6299	3002	6439	3101	120.5	120.4
35-39	4563	2217	5234	2497	5330	2538	5367	2514	117.6	113.4
40-44	3969	1959	4637	2324	4766	2382	4796	2404	120.8	122.7
45-49	3513	1743	3718	1921	3831	1966	3998	1987	113.8	114.0
50-54	2644	1326	3273	1717	3349	1763	3401	1796	128.6	135.4
55-59	1527	767	2514	1367	2697	1448	2869	1531	187.9	199.6
60-64	893	463	1562	850	1700	953	1872	1044	209.6	225.5
65-69	640	354	824	458	933	514	1017	569	158.9	160.7
70-89	1234	810	1312	862	1340	875	1356	891	109.9	110.0
90+	33	26	43	34	42	34	45	36	136.4	138.5

Дээрхи хүснэгтийн 2018 оныг 2010 онтой харьцуулсан үзүүлэлтээс харахад 5-9 насны хүн ам 47.2 хувиар өссөн байна.


ХҮСНЭГТ2.4 ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, 1979,1989,2000,2010,2014-2018 онд

	1979*	1989*	2000*	2010*	2014	2015	2016	2017	2018
Хүн ам зүйн ачаалал	99.5	90.9	66.0	48.8	49.0	52.8	51.4	51.9	54.0
0-14 насны хүүхэд	18.6	24.6	18.3	17.1	18.8	19.7	20.4	21.0	21.9
15-64 хөдөлмөрийн нас	21.3	29.9	30.5	38.9	42.6	41.3	44.0	44.9	45.2
65+ дээш	2.6	2.6	1.8	1.9	2.0	2.1	2.2	2.3	2.5

Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илүү харуулж чадах, эдийн засгийн тодорхой ач холбогдолтой үзүүлэлт бол хүн ам зүйн ачаалал юм. Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн харьцааг хүн ам зүйн ачаалал гэнэ. Хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, өндөр настны тоо нь хүн амын нийгэм, эдийн засгийн чухал үзүүлэлтийн нэг юм.

Хүн ам зүйн ачаалал 1979 онд 99.5 хувь, 1989 онд 90.9 хувь, 2000 онд 66.0 хувь, 2010 онд 49.0 хувьд хүрч тооллогоос тооллогын хооронд буурчээ. 2018 онд хүн ам зүйн ачаалал 54.0 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.1 пунктээр өсөв.

ЗУРАГ2.3. ХҮН АМЫН ТООНЫ БҮТЭЦ, НАСНЫ АНГИЛЛААР




2018 онд 31.5 хувийг хүүхэд, 64.9 хувийг хөдөлмөрийн насны, 3.6 хувийг тэтгэвэрийн насны хүн ам эзэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 0-14 насны хүүхэд 0.7 пунктээр, 65-аас дээш насны хүн ам 0.2 пунктээр тус тус өсч, хөдөлмөрийн насны \15-59нас\ хүн ам өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр буурсан үзүүлэлт гарлаа.

ГУРАВ. ХҮН АМЫН СУУРЬШИЛТ, НЯГТРАЛ

Нийт хүн амын 63.5 хувь нь хот (аймгийн төв), тосгонд, 13.9 хувь нь сумын төвд, 22.6 хувь нь хөдөөд амьдарч байна.

ЗУРАГЗ.1 НИЙТ ХҮН АМЫН ТОО, СУУРЬШИЛ, бүтцээр, 2010,2018 онд



2018 оны суурьшлийн байдлыг 2010 оны тооллоготой харьцуулахад хот (аймгийн төв), тосгонд амьдарч буй хүн амын эзлэх хувь 2.9 пунктээр өсч, сумын төвд амьдарч буй хүн ам 1.3 пунктээр, хөдөө амьдарч байгаа хүн амын эзлэх хувь 1.6 пунктээр тус тус буурчээ.

ХҮСНЭГТЗ.1. ХҮН АМЫН ТОО, СУУРЬШИЛ, сумдаар,2016-2018 он

	2016		2017		2018	
	Сумын төвд	Хөдөөд	Сумын төвд	Хөдөөд	Сумын төвд	Хөдөөд
Бүгд	50999	15607	52333	15859	53871	15689
Айраг	2453	1285	2461	1350	2401	1365
Алтанширээ	298	996	292	1035	300	1060
Даланжаргалан	711	2031	728	2021	815	2080
Дэлгэрэх	355	1534	347	1526	318	1522
Иххэт	995	1082	979	1129	957	1155
Мандах	334	1234	325	1262	322	1274
Өргөн	1066	867	1086	918	1098	978
Сайхандулаан	370	997	369	1011	367	1011
Улаанбадрах	364	1110	333	1137	308	1174
Хатанбулаг	573	2368	574	2345	940	1932
Хөвсгөл	420	1148	417	1156	403	1137
Эрдэнэ	1482	955	1409	969	1438	1001
Сайншанд	24059		24772		25274	
Замын Үүд	17519		18241		18930	

* -Хүн амын тооллого явагдсан онууд

ЗУРАГ3.2 МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ, мян.км2



Монгол улс 1564.9 мян.км2 нутаг дэвсгэртэй бөгөөд төвийн бүс нь 473.6 мян.км2 буюу 30.3 хувийг эзлэдэг байна.

Дорноговь аймаг нь 109.4 мян.км2 нутаг дэвсгэртэй бөгөөд Монгол улсын нийт газар нутгийн 6.7

хувийг, төвийн бүсийн газар нутгийн 23.1 хувийг эзэлдэг байна

109.4 мянган кв.км нутаг дэвсгэрт 69.6 мянган хүн ам оршин суудаг бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 0.64 хүн ногдож байгаа нь 2010 оны тооллогын дүнгээс 0.11 пунктээр нэмэгдлээ. Замын-Үүд, Сайншанд, Даланжаргалан сумын хүн амын нягтрал аймгийн дунджаас дээгүүр байна.


ХҮСНЭГТ3.2 ХҮН АМЫН НЯГТРАЛ, СУМААР. 1989, 2000, 2010, 2018 он

	км2	Нэг кв.км.т ногдох хүний тоо							
		1989*		2000*		2010*		2018	
		Тоо	Нягтшил	Тоо	Нягтшил	Тоо	Нягтшил	Тоо	Нягтшил
Бүгд	109 400	57 103	0.52	50 575	0.46	57 930	0.53	69560	0.64
Айраг	7 400	3 155	0.43	3 467	0.47	3 877	0.52	3766	0.51
Алтанширээ	7 200	1 544	0.21	1 547	0.21	1 191	0.17	1360	0.19
Даланжаргалан	4 100	2 251	0.55	2 332	0.57	2 600	0.63	2895	0.71
Дэлгэрэх	4 800	1 673	0.35	1 893	0.39	1 704	0.36	1840	0.38
Иххэт	4 200	3 886	0.93	2 701	0.64	2 107	0.50	2112	0.50
Мандах	12 700	1 717	0.14	1 905	0.15	1 422	0.11	1596	0.13
Өргөн	8 700	1 951	0.22	2 028	0.23	1 701	0.20	2076	0.24
Сайхандулаан	9 500	1 367	0.14	1 281	0.13	1 162	0.12	1378	0.15
Улаанбадрах	11 400	1 489	0.13	1 731	0.15	1 456	0.13	1482	0.13
Хатанбулаг	18 700	2 661	0.14	3 362	0.18	3 018	0.16	2872	0.15
Хөвсгөл	8 400	1 456	0.17	1 720	0.20	1 540	0.18	1540	0.18
Эрдэнэ	9 600	2 171	0.23	2 832	0.30	2 220	0.23	2439	0.25
Сайншанд	2 300	21 069	9.16	18 290	7.95	20 643	8.98	25274	10.99
Замын Үүд	400	1 458	3.65	5 486	13.72	13 289	33.22	18930	47.33

Сумдын хүн амыг нягтралаар бүлэглэвэл Алтанширээ, Мандах, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумдын 1 км2-д ногдох хүний тоо 0.13-0.19, Эрдэнэ, Өргөн, сумдын 1 км2-д ногдох хүний тоо 0.24-0.25, Айраг, Даланжаргалан, Иххэт

сумдын 1 км²-д ногдох хүний тоо 0.38-0.71, Сайншанд, Замын-Үүд сумдын 1 км²-д ногдох хүний тоо 10.99, 47.33 байна.

ЗУРАГ3.3. СУМДЫН ХҮН АМЫН АЙМГИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2018 он



Сумдын хүн амын нийт дүнд эзлэх хувийг 2010 онтой харьцуулахад Сайхандулаан сумын эзлэх хувь адил хэмжээнд, Сайншанд, Замын-Үүд, Өргөн сумдын эзлэх хувь 0.1-4.9 пунктээр нэмэгдэж, бусад сумдын хүн амын нийт дүнд эзлэх хувь буурсан байна.

ХҮСНЭГТ3.3 СУМДЫН ХҮН АМЫН ТООНЫ БҮЛЭГЛЭЛТ, 2018 он

	Бүлэгт багтах сумын тоо	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
1000-2000	6	9196	13.2
2000-3000	5	12394	17.8
3000-4000	1	3766	5.4
10000-20000	1	18930	27.2
20000+	1	25274	36.3
Бүгд	14	69560	100.0

Дорноговь аймгийн 14 сумын хүн амын тоог бүлэглэн үзвэл 1.0-2.0 мянган хүн амтай сум 6, 2.0-3.0 мянган хүн амтай сум 5, 3.0-4.0 мянган хүн амтай сум 1, 10.0-20,0 мянган хүн амтай сум 1, 20.0 мянгаас дээш хүн амтай сум 1 байна.

ДӨРӨВ.ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН

2018 онд Дорноговь аймагт 829 хүү, 767 охин нийт 1596 шинэ хүн мэндэлж, 407 хүн нас барж, 1000 хүнд ногдох хүн амын ердийн цэвэр өсөлт 15.0 болжээ. Өмнөх онтой харьцуулбал төрсөн хүүхдийн тоо 15.2 хувиар, нас барсан хүний тоо 13.1 хувиар тус тус өсчээ.

ХҮСНЭГТ4.1 ХҮН АМЫН ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, хүйс, байршлаар

		2015	2016	2017	2018	2018 2015	2018 2017
	Бүгд	1667	1527	1386	1596	95.7	115.2
Төрөлт, бодит тоогоор	эр	848	805	727	829	97.8	114.0
	эм	819	722	659	767	93.7	116.4
	хотод	1105	938	897	597	54.0	66.6
	хөдөөд	562	589	489	999	177.8	204.3
	Бүгд	350	391	360	407	116.3	113.1
Нас баралт бодит тоогоор	эр	236	241	238	248	105.1	104.2
	эм	114	150	122	159	139.5	130.3
	хотод	208	235	212	139	66.8	65.6
	хөдөөд	142	156	148	268	188.7	181.1
	Бүгд	22	18	16	18	x	x
Хүн амын ердийн цэвэр өсөлт, 1000 хүнд ногдох	эр	20	18	15	17	x	x
	эм	23	18	17	18	x	x
	хотод	25	18	18	11	x	x
	хөдөөд	17	18	14	29	x	x
1000 хүн амд ногдох төрөлт		26.3	23.5	20.6	23.2	x	x
1000 хүн амд ногдох нас баралт		5.5	6.0	5.3	5.9	x	x
Төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа		103.5	111.5	110.3	108.1	x	x
Нас барсан хүний хүйсийн харьцаа		207.0	160.7	195.1	156.0	x	x

1000 хүн амд ногдох төрөлт 23.2, нас баралт 5.9 байгаа нь 2017 оноос төрөлт 2.6 пунктээр, нас баралт 0.6 пунктээр тус тус өссөн байна.

Төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 108.1, нас барсан хүний хүйсийн харьцаа 156.0 байна. Төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа өмнөх оноос 2.2 пунктээр, нас барсан хүний хүйсийн харьцаа 39.1 пунктээр тус тус буурчээ.

ХҮСНЭГТ4.2. ТӨРҮҮЛСЭН ХҮҮХЭД, эхийн насаар, 2018 он

Эхийн насны бүлэг	Эмэгтэйчүүдийн тоо	Төрсөн хүүхэд төрүүлсэн эхийн насны бүлгээр	Үүнээс:	
			Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	28798	1596	829	767
15 хүртэлх	10578	0	0	0
15-19	2661	99	46	53
20-24	2573	410	218	192
25-29	2980	480	250	230
30-34	3101	362	175	187
35-39	2514	191	113	78
40-44	2404	51	27	24
45-49	1987	3	0	3

2018 онд 1000 хүн амд ногдох төрсөн хүүхэд 23.2 байгаа бол төрөх насны 1000 эмэгтэйд ногдох төрөлт 55.4 байна. Насны ангиллаар авч үзвэл төрөх насны 20-24 насанд 159.3, 25-29 насанд 161.1 ногдож байгаа нь хамгийн өндөр юм. 2018 онд 20-29 насны эмэгтэйчүүдийн 55.8 хувь нь хүүхэд төрүүлсэн нь нийт төрөлтийн дийлэнхи хувь болж байна.

ХҮСНЭГТ4.3 ТӨРӨЛТИЙН ТУСГАЙ КОЕФФИЦИЕНТ, насны бүлгээр, оны эцэст

Насны бүлэг	2014	2015	2016	2017	2018
15 хүртэлх					0.0
15-19	36	44.9	36.0	36.8	37.2
20-24	166.2	178.6	148.4	133.4	159.3
25-29	159.5	159.3	144.2	133.9	161.1
30-34	125.0	133.8	118.9	91.3	116.7
35-39	85.1	89.4	74.9	75.7	76.0
40-44	25.5	19.6	23.7	23.1	21.2
45-49	3.7	3.3	2.1	1.0	1.5
ТТК	94.6	98.0	84.7	48.7	55.4
ТЕК	26.6	26.3	23.5	20.6	23.2

ТТК - төрөлтийн тусгай коэффициент

ТЕК - төрөлтийн ерөнхий коэффициент

ХҮСНЭГТ4.4 ХҮҮХЭД ТӨРҮҮЛСЭН ЭХЧҮҮДИЙН НАСНЫ БҮТЭЦ, хувиар

Эхийн насаар	2013	2014	2015	2016	2017	2018
15 хүртэлх	0.1	0.1	0.1	0.0	0.1	0.0
15-19	6.0	5.5	6.7	6.2	7.1	6.2
20-24	30.0	28.6	27.5	25.1	24.5	25.7
25-29	29.5	30.0	29.1	29.9	30.7	30.1
30-34	19.8	19.5	21.2	22.7	19.8	22.7
35-39	11.7	12.7	12.7	12.2	13.9	12.0
40-44	2.9	3.2	2.5	3.6	4.0	3.2
45-49	0.1	0.4	0.4	0.3	0.1	0.2
Төрсөн хүүхэд бүгд	100.0	100.0	100.0	100	100	100

Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн насны бүтцийг авч үзвэл 15-19 насанд 6.2 хувь, 20-24 нас 25.7 хувь, 25-29 нас 30.1 хувь, 30-34 нас 22.7 хувь, 35-39 нас 12.0 хувь бусад насныхан 3.4 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ4.5 ХҮҮХЭД ТӨРҮҮЛСЭН ЭХЧҮҮДИЙН БОЛОВСРОЛЫН БҮТЭЦ, хувиар

	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Магистр, диплом болон бакалаврын дээд	33.6	38.0	37.5	37.1	33.5	44.4
Тусгай мэргэжлийн дунд	1.8	1.9	2.3	2.5	3.7	2.4
Бүрэн дунд, ТМД	42.6	39.4	42.5	36.3	50.2	41.4
Бүрэн бус дунд	14.5	16.4	14.2	20.0	9.4	9.0
Бага	6.2	3.6	3.1	3.6	2.8	1.9
Боловсролгүй	1.3	0.8	0.5	0.5	0.4	0.9

Эхчүүдийн 44.4 хувь нь дээд боловсролтой, 2.4 хувь нь тусгай дунд мэргэжилтэй, 41.4 хувь нь бүрэн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 9.0 хувь нь бүрэн бус дунд, 2.8 хувь нь бага болон боловсролгүй эмэгтэйчүүд байна.


2018 онд хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 84.8 хувь нь гэр бүлтэй, 15.2 хувь нь гэр бүлгүй эмэгтэйчүүд юм. Өмнөх оны мөн үетний харьцуулахад гэр бүлтэй эхчүүд 1.0 пунктээр өсч гэр бүлгүй эхчүүд 1.0 пунктээр буурав.

ЗУРАГ4.1 ХҮҮХЭД ТӨРҮҮЛСЭН ЭХЧҮҮДИЙН ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, хувиар



2018 онд аймгийн хэмжээнд 427 гэр бүл шинээр гэрлэлтээ бүртгүүлсэн нь өмнөх оноос 15.7 хувиар, 84 хос гэрлэлтээ дуусгавар болсон нь өмнөх оноос 27.3 хувиар тус тус өссөн байна. Нийт гэрлэлтийн 402(91.4%) хос нь анх гэрлээд бүртгүүлсэн бол 25(5.9%) хос нь 2 дах удаагаа гэрлэлтээ бүртгүүлсэн байна.

ЗУРАГ4.2 ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТЫН ТОО, 2014-2018 он



Цуцлалтыг гэр бүл байсан хугацаагаар нь харвал 1-3 жил болсон гэр бүл 1(1.2%), 4-6 жил болсон гэр бүл 10(11.9%), 7-9 жил болсон гэр бүл 16(19.0%), 10-14 жил болсон гэр бүл 32(38.1%), 15-аас дээш жил болсон гэр бүл 25(29.8%) гэрлэлтээ цуцлуулсан байна.

ХҮСНЭГТ4.6 ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТЫН ЕРӨНХИЙ, ТУСГАЙ КОЭФФИЦИЭНТ

Он	Жилийн дундаж хүн амын тоо	15 ба түүнээс дээш насны хүн амын тоо	Гэрлэлтийн тоо	Гэрлэлтийн ерөнхий коэффициент	Гэрлэлтийн тусгай коэффициент	Цуцлалтын тоо	Цуцлалтын ерөнхий коэффициент	Цуцлалтын тусгай коэффициент
2014	62988	44649	363	5.8	8.1	88	1.4	1.97
2015	63309	43390	325	5.1	7.5	62	1.0	1.43
2016	64866	46183	330	5.1	7.1	67	1.0	1.45
2017	67399	47220	369	5.5	7.8	66	1.0	1.40
2018	68876	47622	427	6.2	9.0	84	1.2	1.76

Гэрлэлтийн ерөнхий коэффициентоос харахад 2018 онд 1000 хүн тутмын 6 нь, гэрлэлтийн тусгай коэффициентоос харахад 15-аас түүнээс дээш насны 1000 хүн тутмын ойролцоогоор 9 нь шинээр гэр бүл болж байна.

Салалтын ерөнхий коэффициентоос харахад 2018 онд 1000 хүн тутмын 1 нь, салалтын тусгай коэффициентоос харахад 15 ба түүнээс дээш насны 1000 хүн тутмын ойролцоогоор 2 нь гэр бүлээ дуусгавар болгосон байна.

Төрөлт, нас баралт, гэрлэлт, цуцлалт зэрэг хүн ам, эрүүл мэндийн статистик үзүүлэлтийг бусад улс орон болон аймаг нийслэлтэй жишихдээ 1000 хүн амд ногдох үзүүлэлтийг чухалчилдаг.

ХҮСНЭГТ 4.7 ҮРЧЛЭЛТ, хүүхдийн насны бүлгээр

	2014	2015	2016	2017	2018
Бүгд	22	15	14	13	6
Үүнээс: 3 хүртэлх настай насны бүлгээр	11	5	5	9	3
3-6 настай	6	4	3	0	2
7-9 настай	1	3	0	2	0
10 ба дээш настай	4	3	6	2	1

2018 онд 6 хүүхэд үрчлэгдсэн байна. Үүнд 3 хүртэлх насны хүүхэд 3, 3-6 хүртэлх насны хүүхэд 2, 10 ба түүнээс дээш насны 1 хүүхэд байна.

ТАВ. ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Хүн амын шилжих хөдөлгөөн нь аймаг, сумын хүн амын тооны өсөлт, өөрчлөлтийг илэрхийлдэг үндсэн үзүүлэлтийн нэг юм. 2018 онд Дорноговь аймагт 1732 хүн шилжин ирж, 1688 хүн шилжин явснаар, цэвэр шилжилт 44 байгаа нь 2017 оноос 618-оор буурав.

ХҮСНЭГТ 5.2 ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

	2014	2015	2016	2017	2018
Шилжин ирсэн хүний тоо	1516	1505	1607	1882	1732
Шилжин явсан хүний тоо	1590	1912	1547	1220	1688
Цэвэр шилжилт	-74	-407	60	662	44
Шилжилт хөдөлгөөний цэвэр коэффициент, хувиар	-0.12	-0.64	0.09	0.97	0.06

2018 онд шилжилн ирсэн хүний тоо 1732 байгаа нь өмнөх оноос 150(8.0%)-аар буурч, 1688 хүн шилжин явсан нь 2017 оноос 468(38.4%)-аар өссөн байна.


Шилжилт хөдөлгөөний цэвэр коэффициент 2014, 2015 онд бусад аймаг, нийслэл рүү чиглэсэн сөрөг чиглэлтэй -0.12, -0.64 хувь байсан бол 2016 оноос эерэг чиглэлтэй болж 2018 онд 0.06 гэсэн эерэг чиглэлтэй болсон байна.

ХҮСНЭГТ 5.1 2018 ОНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ УРСГАЛ

	Ирсэн		Явсан		Цэвэр шилжилт
	Шилжин ирсэн хүний тоо	Дунд эзлэх хувь	Шилжин явсан хүний тоо	Дунд эзлэх хувь	
Шилжигчид-бүгд	1732	100.0	1688	100.0	44
<i>Шилжих хөдөлгөөний сөрөг урсгал</i>					
Архангай	22	1.3	23	1.4	-1
Баянхонгор	33	1.9	35	2.1	-2
Дархан-Уул	75	0.4	88	5.2	-13
Сэлэнгэ	102	5.9	115	6.8	-1
Сөрөг урсгалын дүн	232	13.4	261	15.5	-29
<i>Шилжих хөдөлгөөний эерэг урсгал</i>					
Баян-Өлгий	12	0.7	11	0.7	1
Булган	18	1.0	18	1.1	0
Говь-Алтай	17	1.0	10	0.6	7
Говьсүмбэр	147	8.5	144	8.5	3
Дорнод	66	3.8	54	3.2	12
Дундговь	56	3.2	54	3.2	2
Завхан	28	1.6	28	1.7	0
Орхон	60	3.5	59	3.5	1
Өвөрхангай	34	2.0	31	1.8	3
Өмнөговь	87	5.0	79	4.7	8
Сүхбаатар	112	6.5	107	6.3	5
Төв	62	3.6	61	3.6	1
Увс	20	1.2	20	1.2	0
Улаанбаатар	592	34.2	569	33.7	23
Ховд	32	1.8	31	1.8	1
Хөвсгөл	44	2.5	41	2.4	3
Хэнтий	113	6.5	110	6.5	3
Эерэг урсгалын дүн	1500	86.6	1427	84.5	73

Шилжин ирсэн хүн амын 35.0 хувь нь 0-14 насны хүүхэд, 19.2 хувь нь 15-24 насны залуучууд, 27.4 хувь нь 25-34 насны, 14.1 хувь нь 35-49 насны, 4.2 хувь нь 50-аас дээш насны хүн ам юм.

ЗУРАГ 5.1 ШИЛЖИН ИРСЭН, ЯВСАН ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, хувиар



Сүүлийн 16 жилийн шилжилт хөдөлгөөнөөс харахад 2005 оноос шилжилт хөдөлгөөнд бүртгэгдсэн иргэдийн шилжин явсан иргэдийн эзлэх хувь бага зэрэг буурч, 2018 онд шилжилт хөдөлгөөний бүртгэлд хамрагдсан хүн амын 50.6 хувь нь шилжин ирж, 49.4 хувь нь шилжин явсан байна.

Шилжин ирсэн хүн амын 34.2 хувь Улаанбаатар хот, 8.5 хувь нь Говьсүмбэр аймаг, 6.5 хувь нь Хэнтий, Сүхбаатар аймгаас, 5.0 хувь Өмнөговь аймгаас, шилжин явсан хүн амын 33.7 хувь нь Улаанбаатар хот, 8.5 хувь Говьсүмбур аймаг, 6.5 хувь Хэнтий аймаг, 6.3 хувь нь Сүхбаатар аймаг руу тус тус шилжин явж, ирсэн нь хамгийн өндөр хувь байна.

Б. ХҮН АМ НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ


2018 оны эцэст 21286 өрхтэй болсон бөгөөд энэ нь өмнөх оныхоос 442(2.1%) өрхөөр нэмэгдэж нэг өрхөд ногдох хүний тоо 3.3 байна. Нийт өрхийн 58.7 хувь нь аймгийн төв, тосгонд, 41.3 хувь нь сумын төв, хөдөөд амьдарч байгаа нь хотожсон аймаг болохыг харуулж байна.

ХҮСНЭГТ 6.1 ӨРХИЙН ТОО. сумаар, байршлаар, оны эцэст

	Бүгд		Үүнээс							
			аймгийн төвд		тосгонд		сумын төвд		хөдөөд	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Бүгд	20844	21286	7369	7634	5129	5189	3112	3257	5234	5206
Айраг	1232	1232					773	762	459	470
Алтанширээ	456	474					105	111	351	363
Даланжаргалан	947	980					246	271	701	709
Дэлгэрэх	556	555					113	110	443	445
Иххэт	732	740					338	333	394	407
Мандах	509	506					121	114	388	392
Өргөн	700	725					381	378	319	347
Сайхандулаан	462	466					127	124	335	342
Улаанбадрах	508	507					122	119	386	388
Хатанбулаг	965	970					204	341	761	629
Хөвсгөл	498	498					134	131	364	367
Эрдэнэ	781	810					448	463	333	347
Сайншанд	7369	7634	7369	7634						
Замын - Үүд	5129	5189			5129	5189				

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад аймгийн төвд амьдарч буй хүн 3.6 хувиар, хот тосгонд амьдарч буй хүн 1.2 хувиар, сумын төвд амьдарч буй хүн 4.7 хувиар тус тус өсч, хөдөөд амьдарч буй хүний тоо 0.5 хувиар буурчээ.

ЗУРАГ6.1. ӨРХИЙН АМ БҮЛИЙН ТОО, дүнд эзлэх хувиар, оны эцэст



Нийт өрхийн тоог ам бүлийн тооны хувьд авч үзвэл 1 ам бүлтэй өрх хамгийн их буюу 22.2 хувийг, 4 ам бүлтэй өрх 19.7 хувийг, 3 ам бүлтэй өрх 17.4 хувийг тус тус эзэлж байна.

НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Ихэр хүүхэдтэй өрхийн тоо 2018 онд 231 болж өмнөх оны мөн үеэс 29(14.5%)-өөр, 2 ихэр хүүхдийн тоо 466 болж 2017 оноос 62(15.3%)-оор тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 6.2 ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, сумаар

	Ихэр хүүхэдтэй		2 ихэр хүүхдийн		Эмэгтэй		Гэр бүлгүй өрх	
	2016	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Бүгд	202	231	404	466	2267	2001	402	367
Айраг	14	13	28	26	229	184	39	39
Алтанширээ	4	4	8	8	42	35	11	7
Даланжаргалан	4	7	8	14	69	75	28	24
Дэлгэрэх	8	7	16	14	79	68	32	20
Иххэт	11	10	22	20	145	118	54	41
Мандах	3	3	6	8	46	47	6	16
Өргөн	9	9	18	18	95	89	34	35
Сайхандулаан	4	5	8	10	34	34	4	12
Улаанбадрах	2	1	4	2	50	46	4	6
Хатанбулаг	8	9	16	18	96	90	18	14
Хөвсгөл	4	8	8	18	35	55	2	11
Эрдэнэ	5	7	10	14	98	89	34	31
Сайншанд	82	93	164	186	1139	957	124	99
Замын - Үүд	44	55	88	110	110	114	12	12

2018 онд өрх толгойлсон эцэг, эхийн тоо 2368 болж өмнөх оны мөн үеэс 298(11.2%)-аар буурчээ.

ХҮСНЭГТ 6.3 ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, сумаар

	Тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй ахмад настай хүний тоо		18 хүртэлх насны 4 түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо		Алдар эхийн 1-р одонтой эхийн тоо		Алдар эхийн 2-р одонтой эхийн тоо	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Бүгд	5	20	782	732	(x)	1285	(x)	2621
Айраг	1		66	43	(x)	117	(x)	219
Алтанширээ			17	19	(x)	54	(x)	80
Даланжаргалан			53	43	(x)	94	(x)	136
Дэлгэрэх		1	22	21	(x)	71	(x)	94
Иххэт			29	30	(x)	72	(x)	133
Мандах			21	16	(x)	55	(x)	79
Өргөн		2	53	16	(x)	46	(x)	104
Сайхандулаан			12	18	(x)	40	(x)	59
Улаанбадрах	4	1	8	22	(x)	48	(x)	70
Хатанбулаг			38	46	(x)	86	(x)	137
Хөвсгөл			17	19	(x)	56	(x)	83
Эрдэнэ		2	28	10	(x)	76	(x)	131
Сайншанд		12	246	260	(x)	362	(x)	892
Замын - Үүд		2	172	169	(x)	108	(x)	404

Тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй ахмад настай хүний тоо өмнөх оноос 4 дахин өсч, 18 хүртэлх насны 4 түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 6.4 хувиар буурчээ. Одонтой эхчүүдийн мэдээллийг 2018 оноос гаргаж эхэлсэн бөгөөд аймгийн хэмжээнд 1-р зэргийн одонтой эх 1285, 2-р зэргийн одонтой эх 2621 байна.

ЗУРАГ 6.2. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ТООГООР, 2017-2018 он



Өрх толгойлсон эхчүүдийн 1071(53.5%) нь 3 хүртэлх, 812(40.6%) нь 3-5 гишүүнтэй, 118(5.9%) нь 6 түүнээс дээш гишүүнтэй өрхийг толгойлж байна.


Өнчин хүүхдийн тоо 2018 онд 834 болж, өмнөх оноос 32-оор нэмэгджээ. Нийт өнчин хүүхдийн 54(6.5%) нь бүтэн өнчин, 780(93.5%) нь хагас өнчин хүүхдүүд юм.

ЗУРАГ6.3. ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, 2009-2018 онд



Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2018 оны эцэст 2598 болж өмнөх оноос 46(1.8%)-аар өсчээ. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 8.0 хувийг 0-14 насны хүүхэд эзэлж байна.

ЗУРАГ6.4 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, 0-14 НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТОО, 2009-2018 онд



ХҮСНЭГТ.6.4 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, төрлөөр, 2018 онд

		Бүгд	Харааны	Ярианы	Сонсголын	Хөдөлгөөний	Сэтгэц	Хавсарсан	Бусад	
Бүгд		2598	306	90	189	734	479	125	675	
Эмэгтэй		1003	91	38	80	254	230	34	276	
Хөдөлмөр эрхэлдэг		417	57	12	37	139	59	12	101	
Төрлөөр	Төрөлхийн	874	92	72	76	180	310	43	101	
	Олдмол	1724	214	18	113	554	169	82	574	
	Өвчнөөр	Ердийн өвчин	1140	140	16	93	292	128	41	430
		Мэргэжлээс шалтгаалсан өвчин	142	4		5	37	8	32	56
	Осол гэмтлээр	Зам тээврийн осол	138	16	1	2	79	4	1	35
		Үйлдвэрлэлийн осол	42	10		4	13	5		10
		Ахуйн осол	262	44	1	9	133	24	8	43

Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 1003(38.6%) нь эмэгтэйчүүд, 16.1 хувь нь буюу 417 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний 874(33.6%) нь төрөлхийн, 1724(66.4%) нь олдмол, үүнээс 66.1 хувь нь ердийн өвчний, 15.2 хувь нь ахуйн осол, 8.2 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөс, 8.0 хувь нь зам тээврийн ослоос, 2.4 хувь нь үйлдвэрийн ослын шалтгаантай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 734(28.3%) хөдөлгөөний, 675(26.0%) нь бусад төрлийн, 479(18.4%) нь сэтгэцийн, 306(18.8%) нь харааны, 189(7.3%) нь сонсголын, 125(4.8%) нь хавсарсан, 90(3.5%) нь ярианы бэрхшээлтэй иргэд байна.

7.ХАВСРАЛТ

7.1 ХҮН АМЫН ТОО, НАСНЫ АНГИЛЛААР, ХҮЙСЭЭР

	0-14 нас			15-64 нас		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
1979*	18585	9293	9292	21269	11018	10251
1989*	24581	12370	12211	29911	15350	14561
2000*	18320	9026	9294	30472	15800	14672
2008	16099	8052	8047	37551	18532	19019
2009	16678	8379	8299	39088	19291	19797
2010*	17119	8527	8592	38904	19986	18918
2011	17282	8722	8560	41197	20751	20446
2012	17636	8893	8743	41372	20827	20545
2013	18453	9327	9126	42071	21087	20984
2014	18843	9570	9273	42621	21389	21232
2015	19735	10020	9715	41305	20695	20610
2016	20423	10431	9992	44004	22046	21958
2017	20972	10746	10226	44905	22478	22427
2018	21938	11304	10634	45204	22690	22514

	65 дээш нас			18 түүнээс дээш нас		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
1979*	2568	1026	1542	21147	10684	10463
1989*	2611	1026	1585	29413	14873	14540
2000*	1783	689	1094	28885	14739	14146
2008	1988	774	1214	36009	17540	18469
2009	1967	765	1202	37668	18351	19317
2010*	1907	717	1190	39550	19610	19940
2011	1971	730	1241	39910	19831	20079
2012	1927	728	1199	40116	19968	20148
2013	1960	744	1216	40885	20306	20579
2014	2028	764	1264	41605	20658	20947
2015	2085	787	1298	40347	19966	20381
2016	2179	825	1354	42965	21271	21694
2017	2315	892	1423	41721	20906	20815
2018	2418	922	1496	44606	22136	22470

ХҮСНЭГТ7.2 1000 ХҮН АМД НОГДОХ ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, сумаар, оны эцэст

	Төрсөн хүүхэд		Нас барсан		Гэрлэлт		Цуцлалт	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Бүгд	1386	1596	360	407	369	427	66	84
Айраг	95	83	24	32	10	13	4	1
Алтанширээ	26	35	9	15	17	13	1	1
Даланжаргалан	54	65	23	25	10	11	2	2
Дэлгэрэх	33	38	7	13	11	9	1	2
Иххэт	33	53	10	12	14	7	3	1
Мандах	42	33	7	7	13	6	1	1
Өргөн	33	40	10	14	12	10	1	0
Сайхандулаан	23	30	10	10	6	5	1	1
Улаанбадрах	18	29	9	20	3	8	0	0
Хатанбулаг	47	43	18	15	10	9	1	1
Хөвсгөл	35	29	9	11	3	2	0	0
Эрдэнэ	50	48	12	11	8	12	0	1
Сайншанд	532	597	137	139	170	183	36	45
Замын Үүд	365	473	75	83	82	139	15	28

ХҮСНЭГТ7.3 1000 ХҮН АМД НОГДОХ ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, сумаар, оны эцэст

	1000 хүнд ногдох төрөлт				1000 хүнд ногдох нас баралт			
	2015	2016	2017	2018	2015	2016	2017	2018
Бүгд	26.4	26.3	23.5	23.2	5.5	6.0	5.3	5.9
Айраг	27.2	26.1	25.2	21.9	4.4	5.4	6.4	8.4
Алтанширээ	21.2	25.0	19.8	26.1	10.2	8.6	6.9	11.2
Даланжаргалан	25.9	23.6	19.7	23.0	6.0	6.3	8.4	8.9
Дэлгэрэх	28.0	23.5	17.5	20.5	5.9	9.1	3.7	7.0
Иххэт	15.5	24.8	15.8	25.1	4.4	9.2	4.8	5.7
Мандах	26.8	23.6	26.6	20.7	4.5	4.5	4.4	4.4
Өргөн	24.3	19.9	16.8	19.6	6.3	6.3	5.1	6.9
Сайхандулаан	24.1	36.1	16.7	21.8	4.7	4.5	7.3	7.3
Улаанбадрах	26.4	16.5	12.2	19.6	5.6	9.6	6.1	13.6
Хатанбулаг	20.1	21.4	16.0	14.9	6.0	3.9	6.1	5.2
Хөвсгөл	19.4	24.0	22.3	18.6	7.1	6.5	5.7	7.1
Эрдэнэ	17.1	23.9	20.8	19.9	6.8	5.0	5.0	4.6
Сайншанд	27.9	23.2	21.8	23.9	6.4	6.9	5.6	5.6
Замын-Үүд	29.1	23.4	20.4	25.4	3.9	4.3	4.2	4.5

ХҮСНЭГТ7.4 ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН, шилжилт хийгдсэн аймаг, нийслэлээр

	ШИЛЖИЖ ИРСЭН ХҮНИЙ ТОО				ШИЛЖИН ЯВСАН ХҮНИЙ ТОО			
	2015	2016	2017	2018	2015	2016	2017	2018
Бүгд	1505	1607	1882	1732	1912	1547	1220	1688
Архангай	15	22	16	22	6	1	5	23
Баян-Өлгий	7	1	3	12	2	1	3	11
Баянхонгор	21	11	18	33	4	9	22	35
Булган	8	17	12	18	11	13	23	18
Говь-Алтай	7	12	11	17	1	0	4	10
Дорнод	56	43	76	66	41	44	54	54
Дундговь	38	44	73	56	27	28	40	54
Завхан	22	10	21	28	10	4	6	28
Өвөрхангай	30	22	33	34	23	18	19	31
Өмнөговь	70	44	77	87	69	91	138	79
Сүхбаатар	66	91	103	112	105	42	82	107
Сэлэнгэ	56	73	126	102	36	54	64	115
Төв	52	31	70	62	37	16	45	61
Увс	13	30	27	20	1	6	9	20
Ховд	3	18	11	32	0	4	2	31
Хөвсгөл	33	44	49	44	32	23	40	41
Хэнтий	103	123	116	113	85	91	111	110
Дархан-Уул	73	45	55	75	43	31	72	88
Улаанбаатар	721	783	811	592	1201	937	331	569
Орхон	49	49	48	60	42	27	46	59
Говьсүмбэр	62	94	126	147	136	107	104	144

ХҮСНЭГТ7.5 ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, 2015-2018 оноор

	Бүтэн өнчин хүүхэд				Хагас өнчин хүүхэд			
	2015	2016	2017	2018	2015	2016	2017	2018
Бүгд	54	60	54	54	673	695	748	780
Айраг	2	2	1	2	88	83	75	70
Алтанширээ	0	0	0	2	18	13	19	20
Даланжаргалан	2	1	1	1	22	28	34	37
Дэлгэрэх	0	0	0	0	15	14	11	12
Иххэт	4	4	6	6	30	22	25	26
Мандах	1	1	1	1	17	22	21	18
Өргөн	1	3	2	2	17	13	11	19
Сайхандулаан	1	1	0	0	13	11	9	11
Улаанбадрах	2	0	0	0	18	17	17	23
Хатанбулаг	0	0	0	1	47	48	33	36
Хөвсгөл	0	0	0	0	27	25	21	24
Эрдэнэ	3	4	3	3	21	19	15	17
Сайншанд	26	24	24	21	220	238	271	279
Замын - Үүд	12	20	16	15	120	142	186	188

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дорноговь аймаг нь 109.4 мянган км.кв нутаг дэвсгэртэй, 69.6 мянган хүн амтай бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 0.64 хүн ногдож, нэг өрхийн ам бүлийн дундаж тоо 3.3 болжээ.

2018 оны эцэст 69560 байнгын оршин суугчтай болж 2017 оны жилийн эцсийн суурин хүн амын мэдээнээс 1368 хүнээр өсчээ.

Хүн амын тооны өөрчлөлтийг төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнөөр тодорхойлдог бөгөөд энэ нь тухайн үеийн улс төр, нийгэм, хүн ам зүйн хөгжлөөс ихээхэн хамаардаг.

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжэхээс өмнө буюу 1956-1979 оны хооронд 1.9-3.3 хувиар тогтвортой өсч ирсэн нь тус аймгийн Айраг (1963он), Хажуу-Улаан (1973он) сумдад хайлуур жоншны олборлох үйлдвэрүүд байгуулагдан шилжих хөдөлгөөн болон хүн амын эрүүл мэндийн түвшин дээшилж, төрөлт нэмэгдэхийн зэрэгцээ нас баралт буурсантай холбоотой юм.

Харин 1989-2000 онд хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь -1.1 болж буурахад 1000 хүн амд ногдох төрөлт жилд дунджаар 24 болж өмнөх онуудаас 40.0 гаруй хувиар буурсан. Мөн Дорноговь аймгийн бүрэлдэхүүнд байсан Сүмбэр сумыг салгаж Говьсүмбэр аймаг болгон өөрчилсөн нь голлон нөлөөлсөн. 2010-2018 онд Айраг, Хатанбулаг сумдад хүн амын тоо 0.32-0.55 хувиар буурч, бусад сумдад хүн амын тоо жилд дунджаар 0.01-4.01 хувиар өслөө.

2018 онд Дорноговь аймагт 1732 хүн шилжин ирж, 1688 хүн шилжин явснаар, цэвэр шилжилт 44 байгаа нь 2017 оноос 618-аар буурлаа. Сүүлийн жилүүдэд хүн амын ердийн өсөлт тогтмол нэмэгдсэн нь хүн амын тоо өсөхөд голлон нөлөөллөө.

2018 онд 1000 хүнд ногдох төрөлт 23.2, 1000 хүнд ногдох нас баралт 5.9 байгаа нь 2017 оноос төрөлт 0.3 пунктээр буурч, нас баралт 0.6 пунктээр нэмэгдсэн байна.

2010 онд манай аймгийн хүн амд 5-19 насныхны эзлэх хувь 2000 онтой харьцуулахад буурсан нь зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс төрөлт буурснаар тайлбарлагдаж байсан бол 2018 онд хадгалагдсан хэвээр 24-35 насны хүн амын нийт хүн амд эзлэх хувь өндөр байна.

0-4 насны хүн амын эзлэх хувь 2010 оны мөн үетэй ойролцоо байгаа нь хүн амын нас хүйсийн суваргаас харагдаж байна. 2018 оны нас хүйсийн суваргаас харахад 0-9 насны хүн амын эзлэх хувь өндөр байгааг сүүлийн 10 гаруй жилд төрсөн хүүхдийн тоо нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм.

Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, өндөр настны тоо буюу хүн ам зүйн ачаалал 1979 онд 99.5 хувь, 1989 онд 90.9 хувь, 2000 онд 66.0 хувь, 2010 онд 48.9 хувьд хүрч тооллогоос тооллогын хооронд буурч 2018 онд 54.0 хувь байна.

2018 онд хүн амын 64.9 хувь нь хөдөлмөрийн насны хүн ам юм. Хүн амын насны бүтцийн тааламжтай үе гэж онцолсон энэ хугацаанд ажлын байрыг нэмэгдүүлэхэд ажиллах хүчний нөөц бололцоо байгааг харуулж байна.

Нийт хүн амын 63.5 хувь нь хот (аймгийн төв), тосгонд, 13.9 хувь нь сумын төвд, 22.6 хувь нь хөдөөд амьдарч байна. 2018 оны суурьшлийн байдлыг 2017 онтой харьцуулахад хот (аймгийн төв), тосгонд амьдарч буй хүн амын эзлэх хувь 0.4 пунктээр нэмэгджээ.

Өрх хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 11.7 хувиар, эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 8.7 хувиар тус тус буурч, ганц биеэрээ амьдарч байгаа өндөр настан өрхийн тоо 18.3 хувиар, тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй ахмад настай хүний тоо 4 дахин өссөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2017 оноос 1.8 хувиар, 2015 оноос 1.9 хувиар нэмэгдлээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 8.0 хувийг 0-14 насны хүүхэд эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа юм.

СУДАЛГААНД АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

- www.1212.mn, dornogovi.nso.mn сайт
- 2018 оны жилийн эцсийн эмхэтгэл
- Статистикийн салбарт мөрдөж ажиллах аргачлалын эмхэтгэл

СУДАЛГААГ ХЯНАСАН:

Хэлтсийн дарга/Х.Өлзийсүрэн/

СУДАЛГААГ БОЛОВСРУУЛСАН:

Хүн ам нийгмийн статистикийн мэргэжилтэн/А.Амарзаяа/

2019 он